

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
08 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 09 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар		Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл						
1	1	<p>8 1.2.5.Иргэдийн зорчих нөхцөлийг хөнгөвчлөх талаар БНСУ-ын холбогдох байгууллагатай хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулж, энэ хүрээнд дараах асуудлыг хэлэлцэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт:</p> <p>-Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрт холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах замаар харилцан нийгмийн даатгалаас чөлөөлөх хугацааг нэмэгдүүлэх, төлөгдсөн нийгмийн даатгалын буцаан олголтод хамаарах визийн ангилал хүрээг нэмэгдүүлэх;</p> <p>-БНСУ-д эмчилгээ хийлгэж буй иргэдийг дэмжих зорилгоор тус улсын эмнэлгүүдийн төлбөрийн хөнгөлөлтийг эдлүүлэх болон эрүүл мэндийн даатгалд хамрагдах;</p> <p>- Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй монгол иргэдийн эцэг, эх,</p>	<p>2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9</p>	<p>Засгийн газрын 2023 оны “Монгол Улсын иргэдийн Бүгд Найрамдах Солонгос Улсад зорчих нөхцөлийг хөнгөвчлөх чиглэлээр авах арга хэмжээний тухай” 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Чой Жин Воныг 07 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар:</p> <ul style="list-style-type: none"> - Тогтвортой ажлын байртай, бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэдэд олон удаагийн виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх; - Визийн хүсэлт шийдвэрлэх хугацааг богиносгох асуудалд анхаарал хандуулах; - Виз мэдүүлгийн үйлчилгээг цахимжуулах талаар судалж үзэх зэрэг тодорхой саналуудыг дэвшүүллээ. 	90	

1	2	3	4	5	6	7
		үр хүүхэд, гэр бүлийн зүгээс тус улсад зорчих виз хүсэхэд тодорхой хөнгөлөлт эдлүүлэх.				
Хэсгийн дундаж: 90 хувь						
Нийт дундаж: 90 хувь						

--oo0oo--